



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
САНДАГИЙН БЯМБАЦОГТ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Батын БАТБААТАР

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-27-03, Факс: 32-70-16  
E-mail: batbaatar.b@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2026.05.06 № УИТ-03/4956  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Б.БАТБААТАР



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**  
**Батын БАТБААТАР**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-27-03, Факс: 32-70-16  
E-mail: batbaatar.b@parliament.mn  
http://www.parliament.mn

2026.04.15 № УИХ-03/3965  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хуулийн төсөл өргөн**  
**мэдүүлэх тов тогтоох тухай**

Монгол Улсын Их Хурлын гишүүн миний бие Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дах хэсэгт заасан хууль санаачлах эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу бүрдүүлбэрийг ханган хүргүүлж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн бүрдүүлбэрийг хянан үзэж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хавсралт хуудас

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Б.БАТБААТАР

000011

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН  
БАТЛАВ:**



**Б.БАТБААТАР**

2026 оны 03 дугаар сарын 02 өдөр

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

**1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3-т “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.”

Мөн Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох зургаан үндэслэлийг заахдаа: Ерөнхийлөгчөөр сонгогдсон; хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн; хүндээр өвчилсний улмаас бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлт гаргасныг үндэслэн цаашид гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж Улсын Их Хурал үзсэн; Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т зааснаар гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн; гишүүн гэмт хэрэг үйлдсэн болох нь хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр тогтоогдсон; нас барсан гэж;

Гэвч Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1-т “... Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” гэж тус тус заасан боловч Улсын Их Хурлын сонгуульд хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгогдсон буюу улс төрийн намын төлөөлөх төв байгууллагын шийдвэрээр Улсын Их Хурлын сонгуулийн нэр дэвшигчийн жагсаалтад бичигдэж, Улсын Их Хурлын гишүүн болсон хүнд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт тодорхой бус байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн жагсаалтад тухайн намын төлөөлөх төв байгууллагын шийдвэрээр сонгогдож Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон гишүүнийг улс төрийн нам хариуцлага тооцож, эргүүлэн татах санал гарган шийдвэрлүүлэх эрхтэй байх агуулга бүхий зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд тусгах шаардлагатай гэж үзэж байна.

**1.2.Практик шаардлага**

Орчин үед Улсын Их Хурлын гишүүнийг хариуцлагатай байх, парламент дах улс төрийн намын төлөөллийн мандат авсан гишүүнд хариуцлага тооцох ёс зүй, хариуцлага зөрчсөн тохиолдолд Улсын Их Хурлын гишүүнээс эргүүлэн татах талаар олон нийтийн санаа бодол, шаардлага нь мэтгэлцээний гол сэдэв болж байна. Энэ

талаар НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Олон улсын парламентын холбоо хамтран гаргасан “Дэлхийн улс орнуудын парламентын тайлангаас үзэхэд улс төрийн хариуцлагыг сайжруулах олон нийтийн шахалтаас үүдэлтэйгээр парламентын төлөөллийн мөн чанар өөрчлөгдөж, чөлөөт мандатаар сонгогдсон гишүүнийг эргүүлэн татах зэрэг хариуцлагын хэлбэрийг тусгах болсон гэжээ.<sup>1</sup>

Монгол Улсын Улсын Их Хурлын гишүүний хариуцлагыг нэмэгдүүлэх, эргүүлэн татах зохицуулалтыг тодорхой болгох талаар иргэдийн шүүмжлэл улам хүчтэй өрнөж байгаа бөгөөд парламент, улс төрийн намыг иргэдэд нээлттэй ил тод үйл ажиллагаа явуулахыг олон нийтээс хүчтэй шаардаж байна.<sup>2</sup>

Монгол Улсын Их Хурлын гишүүнийг улс төрийн намын саналаар эргүүлэн татах эрх зүйн зохицуулалтыг Үндсэн хуулийн заалтад тулгуурлан Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх (улс төрийн намын мандат)-ийг дуусгавар болох нөхцөлийг тодорхойлж өгөх шаардлагатай. Ингэхдээ Улсын Их Хурлын гишүүнээс эргүүлэн татах үйл явц нь тухайн улс төрийн намын төлөөлөх төв байгууллагаас гишүүнийг эргүүлэн татахаар санал гаргах эрхийг тусгаж, улс төрийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, журмыг нь илүү тодорхой болгох шаардлагатай байна.

Үүнтэй холбоотойгоор 1990 оны Улстөрийн намуудын тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Улсын Их Хурлын гишүүн намыг төлөөлөх боломжгүй гэж үзвэл Улсын Их Хурлын гишүүнээс түүнийг эгүүлэн татах тухай саналаа тухайн нам Улсын Их Хурал дахь өөрийн намын бүлэг болон хууль санаачлах эрх бүхий этгээдээр уламжлан Улсын Их Хуралд тавих эрхтэй.” гэж тусгаж, харин гишүүнийг эргүүлэн татах шийдвэр гаргах эрх нь тухайн үеийн Монгол Улсын Их Хурлын хуулиар Улсын Хуралд хадгалагдаж байжээ.

Монгол Улс 1992 онд Үндсэн хуулиа баталснаас хойш парламентын 9 удаагийн сонгуулийг зохион байгуулсан. Үүнээс 1996, 2000, 2004, 2016 онуудад сонгуулийн жижиг тойрогт Мажоритар системээр, 2012, 2024 онд томсгосон тойрогт Пропорциональ, мажоритар холимгоор, 1992, 2008 онуудад томсгосон буюу олон мандаттай тойрогт Мажоритар системээр тус тус зохион байгуулжээ. Сонгуулийн тогтолцооноос хамаарч тухайн парламент нь өөр өөр арга замаар бүрддэг тул эргүүлэн татах асуудлыг тодорхойлоход сонгуулийн аль системд, ямар хувилбар тохирохыг тооцсон байх учиртай.

Өнөөгийн байдлаар хэрэгжиж байгаа Монгол Улсын Их Хурлын тухай хуульд хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн хэм хэмжээ зөрчсөнтэй холбоотой хариуцлага тооцох зохицуулалт сул, дураар авирлах, төлөөлөн сонгогдсон улс төрийн намын бодлого, шийдвэрийг эсэргүүцэх, парламентын үйл ажиллагаанд оролцохгүй, гишүүний үүргээ биелүүлэхгүй байх зэрэг сөрөг нөхцөл үүсэж, улс төрийн хариуцлага тооцох боломжгүйгээс парламентад итгэх иргэдийн итгэлийг сулруулж байна.

Улс төрийн намын төлөөлөх төв байгууллагын шийдвэрээр Монгол Улсын Их Хуралын сонгуульд жагсаалтад нэр дэвшсэн хувь тэнцүүлэх аргаар сонгогдсон Улсын Их Хурлын гишүүнд тухайн улс төрийн нам хариуцлага тооцож, эргүүлэн татах санал гаргах эрхтэй байх талаар улс төрийн намын гишүүд, анхан болон дунд шатны байгууллагаас удаа дараа санал ирүүлж байгаа нь энэ хуулийн төслийг боловсруулах практик шаардлага болно.

---

<sup>1</sup> Inter-Parliamentary Union | United Nations Development Programme “The changing nature of parliamentary representation” April 2012

<sup>2</sup> Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгаа, 2026 он, хууль санаачлагчийн захиалгын дагуу “Судлаач” ТББ гүйцэтгэсэн.

### **Хоёр.Хуулийн төслөөр зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслөөр Монгол Улсын Их хуралд суудал авсан намын төлөөллийн төв байгууллагаас хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгогдсон Улсын Их Хурлын гишүүнийг эргүүлэн татах санал гаргахтай холбоотой харилцааг зохицуулна.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй Монгол Улсын Их Хурлын тухай хуульд жагсаалтаар сонгогдсон Улсын Их Хурлын гишүүнд тухайн улс төрийн нам хариуцлага тооцож эргүүлэн татах санал гаргах талаар зохицуулалт байхгүй юм.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаарх санал**

Хуулийн төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгэм улс төрийн ямар нэгэн сөрөг үр дагавар үүсэхгүй бөгөөд парламентад итгэх иргэдийн итгэл дээшлэх ач холбогдолтой болно.

### **Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төслийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төслийг дагалдуулан Улс төрийн намын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3-т “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.”

Мөн Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох зургаан үндэслэлийг заасан боловч Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйл. 1-т “... Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” заасан гэж тус тус заасан боловч Улсын Их Хурлын сонгуульд хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгогдсон буюу улс төрийн намын төлөөлөх төв байгууллагын шийдвэрээр Улсын Их Хурлын сонгуулийн нэр дэвшигчийн жагсаалтад бичигдэж, Улсын Их Хурлын гишүүн болсон хүнд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт тодорхой бус байна.

Монгол Улсын Улсын Их Хурлын гишүүний хариуцлагыг нэмэгдүүлэх, эргүүлэн татах зохицуулалтыг тодорхой болгох талаар иргэдийн шүүмжлэл улам хүчтэй өрнөж байгаа бөгөөд парламент, улс төрийн намыг иргэдэд нээлттэй ил тод үйл ажиллагаа явуулахыг олон нийтээс хүчтэй шаардаж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын гишүүнийг улс төрийн намын саналаар эргүүлэн татах эрх зүйн зохицуулалтыг Үндсэн хуулийн заалтад тулгуурлан Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх (улс төрийн намын мандат)-ийг дуусгавар болох нөхцөлийг тодорхойлж өгөх шаардлагатай. Ингэхдээ Улсын Их Хурлын гишүүнээс эргүүлэн татах үйл явц нь тухайн улс төрийн намын төлөөлөх төв байгууллагаас гишүүнийг эргүүлэн татахаар санал гаргах эрхийг тусгаж, улс төрийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, журмыг нь илүү тодорхой болгох шаардлагын үүднээс энэхүү хуулийн төслийг боловсруулав.

Хуулийн төсөл 3 зүйлтэй бөгөөд дараах асуудлыг тусгана. Үүнд:

- Төслийн 1 дүгээр зүйлд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд “9.1.7.Улсын Их хуралд суудал авсан намын төлөөллийн төв байгууллагаас хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгогдсон гишүүнийг эргүүлэн татах шийдвэр гаргасан.” гэсэн зүйл нэмэхээр
- Төслийн 2 дугаар зүйлд Монгол Улсын Их Хурлын 9 дүгээр зүйлийн 9.3 дах хэсгийн “... 9.3 Монгол Улсын Үндсэн хуулийн цэц гишүүнийг тангаргаасаа няцаж Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн...” гэсний дараа “Улсын Их Хуралд суудал авсан намын төлөөллийн төв байгууллагаас хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгогдсон гишүүнийг эргүүлэн татах шийдвэр гаргасан” гэж өөрчлөхөөр тусгана.
- Тус хуулийн төслийг дагалдуулан Улс төрийн намын тухай хуулийн 7 дугаар зүйл нэмэлт оруулах, Монголын Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тус тус өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

Хуулийн төсөл батлагдснаар эдийн засаг, нийгэм улс төрийн ямар нэгэн сөрөг үр дагавар үүсэхгүй бөгөөд парламентад итгэх иргэдийн итгэл дээшлэх ач холбогдолтой болно.

---oOo---

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3-т “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна”.

Мөн Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болох зургаан үндэслэлийг заасан боловч Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйл. 1-т “... Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” заасан гэж тус тус заасан боловч Улсын Их Хурлын сонгуульд хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгогдсон буюу улс төрийн намын төлөөлөх төв байгууллагын шийдвэрээр Улсын Их Хурлын сонгуулийн нэр дэвшигчийн жагсаалтад бичигдэж, Улсын Их Хурлын гишүүн болсон хүнд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт тодорхой бус байна.

Улсын Их Хурлаас 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно” гэж өөрчлөн найруулсан.

Улсын Их Хурлын 2023 оны 44 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 6-д Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд дээрх өөрчлөлттэй нийцүүлэхээр заасан. Дээр дурдсан хууль зүйн үндэслэл, шаардлагад нийцүүлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2024 онд баталсан бөгөөд ингэхдээ Монгол Улсын Их Хурлын гишүүнийг эргүүлэн татах, чөлөөлөх 6 үндэслэлийг дурдан заасан боловч хувь тэнцүүлэх аргаар сонгогдсон гишүүнд хариуцлага тооцох, эгүүлэн татах зохицуулалтыг тодорхой болгоогүй байна.

Сүүлийн үед хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар буюу жагсаалтаар сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдээс намын төлөөлөх байгууллагаас мандат авч сонгогдсон атлаа ёс зүйн зөрчил гаргах, хууль тогтоомж зөрчих, намын эсрэг үйл ажиллагаа, бодлого хэрэгжүүлэх зэрэг байдлууд гарч, цаашлаад олон нийтийн зүгээс болон улстөрийн намын гишүүдээс шүүмжлэл гарч, хариуцлага тооцох, эгүүлэн татахыг шаардах боллоо.

Жагсаалтаар сонгогдсон парламентын гишүүнийг “эгүүлэн татах” нь шууд ардчиллын нэг процедур бөгөөд өөрсдийнх нь сонгосон албан тушаалтан, сонгуультныг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө эгүүлэн татахаар төрийн эрх мэдэл бүхий байгууллага, улстөрийн нам эсхүл тодорхой тооны иргэдийн зүгээс сонгогчдод хандаж, сонгогчид санал, санаачилга гаргасныг үндэслэн эгүүлэн татах процедур юм.

Монгол Улс бол төлөөллийн ардчиллыг хэрэгжүүлэгч орон бөгөөд парламентын гишүүнийг эргүүлэн татах нь шууд ардчиллын хэрэгсэл болохынхоо хувьд улс төрийн намын зүгээс сонгуультны үйл ажиллагаанд сэтгэл хангалтгүй байгаагаа илэрхийлж, тухайн гишүүнд хариуцлага тооцох эрхээ хэрэгжүүлж буй улс төрийн үйлдэл юм. Шууд ардчиллын процедуруудаас эгүүлэн татах асуудал нь төдийлөн өргөн хэрэглэгддэггүй процедур бөгөөд цөөн тооны орны Үндсэн хууль болон бусад хуулиудад сонгуультныг улс төрийн намын саналаар эгүүлэн татах санал гаргасныг парламент нь шийдвэрлэхээр тусгасан байна.

Парламентын гишүүнийг (сонгуульт албан тушаалтныг) сонгогчдын саналаар эгүүлэн татах 2 хэлбэр байна. Үүнд:<sup>1</sup>

1) Сонгогчдын саналаар шууд эргүүлэн татах. Энэ тохиолдолд тухайн сонгуулийн тойргийн бүртгэгдсэн сонгогчдын хэчнээн хувийн санаачилгаар санал асуулга юм уу гарын үсэг цуглуулах процессыг эхлүүлэх, хэчнээн хувийн санал, эсхүл гарын үсэг цугласнаар сонгуультныг эгүүлэн татах зэргийг хуульчлан зохицуулсан байна.

2) Холимог арга. Сонгогчдын санаачилга, саналыг үндэслэн парламент болон бусад эрх бүхий байгууллагаас гишүүнийг эгүүлэн татах шийдвэр гаргах, эсхүл эрх бүхий байгууллагаас гаргасан эгүүлэн татах шийдвэрийг сонгогчид референдумын замаар дэмжих буюу няцаах хэлбэр юм.

Хуулийн төсөлд дараах асуудлыг тусгав: **Монгол Улсын Их Хурлын тухай хуульд:**

№	Хуулийн зүйл, заалтад харгалзах нэмэлт, өөрчлөлтийг оруулсны дараа уншигдах байдал	Тайлбар
<b>Нэмэлт, өөрчлөлт оруулсан</b>		
1.	<b>9 дүгээр зүйлийн 9.1.7 дах заалт:</b> 9.1.7.Улсын Их хуралд суудал авсан намын төлөөллийн төв байгууллагаас хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгогдсон гишүүнийг эгүүлэн татах шийдвэр гаргасан.”	Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулийг зөрчсөн нь Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар түүнийг эгүүлэн татах үндэслэл болох бөгөөд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэ тухай гаргасан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг “хүлээн зөвшөөрсөн бол түүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн

<sup>1</sup> a 249 Charley Coleman and Neil Johnston, Recall elections, Library House of Commons, SN/PC/05089, 2013.

		<p>шийдвэрлэнэ” гэжээ. Гэтэл намын жагсаалтаар сонгогдож Улсын Их Хурлын гишүүн болсны дараа тухайн намын бодлого шийдвэрийн эсрэг ажилласан бол эгүүлэн татах саналыг улс төрийн намын төлөөллийн төв байгууллагаас гаргасан бол эгүүлэн татах эсэхийг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэхээр хуулийн төсөлд томъёолов.</p>
2.	<p><b>9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалт:</b></p> <p>9.3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэц гишүүнийг тангаргаасаа няцаж Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн, <b>Улсын Их Хуралд суудал авсан намын төлөөллийн төв байгууллагаас хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгогдсон гишүүнийг эгүүлэн татах шийдвэр гаргасан</b> бол түүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.</p>	<p>Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн Гишүүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусвар болох тухай 9 дүгээр зүйлд заасан 6 үндэслэл дээр нэг үндэслэл тусгаад үүнтэй холбоотойгоор Улсын Их Хуралд суудал авсан намын төлөөллийн төв байгууллагаас хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгогдсон гишүүнийг эгүүлэн татах шийдвэр гаргасан гэсэн дараагийн процессыг нэмж тусгасан. Улсын Их Хурлын гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, парламент дахь улс төрийн намын төлөөллийн мандат авсан гишүүдэд ёс зүй, хариуцлагын зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага тооцох, цаашлаад Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах асуудал олон нийтийн санаа бодол, шаардлагын төвд орж, өргөн хүрээний мэтгэлцээний гол сэдэв болоод байна. Улс төрийн хариуцлагыг сайжруулах чиглэлд олон нийтийн шахалт нэмэгдсэнтэй холбоотойгоор парламентын төлөөллийн мөн чанарт өөрчлөлт орж, чөлөөт мандатаар сонгогдсон гишүүнийг эгүүлэн татах зэрэг хариуцлагын хэлбэрүүдийг тусгах хандлага бий болсон байна.</p>
3.	<p><b>9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг</b></p> <p>9.4.Энэ хуулийн 9.2, 9.3-т заасан гишүүнийг чөлөөлөх, эгүүлэн татах асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, энэ хуулийн 9.1.4, 9.3-т заасан асуудлаар гишүүн саналаа нууцаар, энэ хуулийн <b>9.1.2, 9.1.3, 9.1.5, 9.1.7-д</b> заасан асуудлаар гишүүн саналаа илээр гаргана. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх гишүүнийг чөлөөлөх, эгүүлэн татахыг дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно.</p>	<p>9 дүгээр зүйлд зарим заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, зарим заалтыг өөрчлөн найруулж, улмаар дугаар өөрчлөгдөж байгаатай холбоотой энэ зүйлийг тусгав.</p>

Хуулийн төсөл батлагдснаар эдийн засаг, нийгэм улс төрийн ямар нэгэн сөрөг үр дагавар үүсэхгүй бөгөөд парламентад итгэх иргэдийн итгэл дээшлэх ач холбогдолтой болно.

---oOo---

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.1.7 дахь хэсэг нэмсүгэй:

“9.1.7. Улсын Их хуралд суудал авсан намын төлөөллийн төв байгууллагаас хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгогдсон гишүүнийг эргүүлэн татах шийдвэр гаргасан.”

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Их Хурлын 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн” гэсний дараа “, Улсын Их Хуралд суудал авсан намын төлөөллийн төв байгууллагаас хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгогдсон гишүүнийг эргүүлэн татах шийдвэр гаргасан” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийн “9.1.5-д заасан асуудлаар” гэснийг “9.1.5, 9.1.7-д заасан асуудлаар” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2026 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“77.1. Энэ хуулийн 4.3.2-т заасан жагсаалтаар нэр дэвшиж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүний орон гарсан бол тухайн нам, эвслийн төлөөллийн байгууллагаас шинээр санал болгосон нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо орон гарснаас хойш 14 хоногийн дотор гаргаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улс төрийн намын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.4.5 дахь заалт нэмсүгэй:

“7.4.5. Улсын Их хуралд суудал авсан намын төлөөллийн төв байгууллагаас хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгогдсон гишүүн намыг төлөөлөх боломжгүй гэж үзвэл Улсын Их Хурлын гишүүнээс түүнийг эргүүлэн татах тухай саналаа Улсын Их Хуралд тавих.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг